



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/259

Улаанбаатар хот

Бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ази, Европын 11 дэх удаагийн дээд хэмжээний уулзалтын арга хэмжээний үеэр эмнэлгийн тусламж, үйлчилгээний болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдлыг хангаж ажиллах албан даалгаврыг хавсралтаар баталсугай.

2. Үндэсний их баяр наадам, Ази, Европын 11 дэх удаагийн дээд хэмжээний уулзалтын үеэр хавсралтаар баталсан албан даалгаврыг хэрэгжүүлэн, хариуцлагатай ажиллахыг Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга А.Эрдэнэтуяад үүрэг болгосугай.

САЙД



С.ЛАМБАА

080943

Эрүүл мэнд, спортын сайдын 2016
оны 07 сарын 07 ны өдрийн А/259
дугаар тушаалын хавсралт



БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ АЛБАН ДААЛГАВАР

Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх, Ази, Европын 11 дэх удаагийн дээд хэмжээний уулзалтыг Монгол улсад зохион байгуулж байгаатай холбогдуулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, бэлэн байдал болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлт, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллах чиглэлээр дараах албан даалгаврыг өгч байна. Үүнд:

1. Баяр наадам, АСЕМ-ын үеэрбүх түвшний эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өндөр сонор сэрэмжтэй байж, ямар ч нөхцөлд холбоо барих боломжтой (гар утсаа нээлттэй байлгах, холбоо барих боломжгүй тохиолдолд байгууллагын хариуцлагатай жижүүрт мэдэгдэх), яаралтай арга хэмжээг зохион байгуулахад бэлэн байх;
2. АСЕМ-ын төлөөлөгчдөд батлагдсан хуваарийн дагуу эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдлыг хангах ажлыг өндөр түвшинд зохион байгуулах;
3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд /халдварт өвчин, хоолны хордлого, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал г.м/, эмнэлзүйн чиглэлээр орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг лавлагаат тусламж, үйлчилгээ, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллах;
4. Бүх шатны эрүүл мэндийн байгууллага иргэдэд тусламж, үйлчилгээг хүлээгдэлгүй, шатлал хоорондын шилжүүлгийн асуудлыг шуурхай зохицуулах арга хэмжээ авах;
5. Туршлагатай эмч нарыг жижүүрт гаргах, хариуцлагатай жижүүр, алсын дуудлаганд явах эмч нарыг батлагдсан хуваарийн дагуу бэлэн байлгаж, цаг хугацаа алдалгүй тусламж үзүүлэх;
6. Хүнд өвчтөн, эх, хүүхдэд тусламжийг шуурхай үзүүлэх, дуудлагын эмч нарыг бэлэн байлгах, эмч нарын зөвлөгөөнийг хугацаа алдалгүй хийж, шаардлагатай тохиолдолд чирэгдэлгүй шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

7. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн удирдамж, стандартыг чанд мөрдөх, аюулгүй ажиллагааг хангах, аливаа эрсдэлээс сэргийлэх,
8. Алсын болон яаралтай түргэн тусламжийн дуудлаганд явах унааг бэлэн байлгах, шатахуун, эм, эмнэлгийн хэрэгсэлийг хангалттай хэмжээгээр нөөцлөх;
9. Эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, цус цусан бүтээгдхүүн, лабораторийн урвалжийг тасалдуулахгүй, оношилгооны бэлэн байдлыг хангах;
10. Эрүүл мэндийн бүх шатны байгууллагууд эхийн эндэгдэл гарахаас сэргийлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, төрөх дөхсөн жирэмсэн эмэгтэйг эхийн амрах байранд урьдчилан авчирч хянах, эх барихын нэн шаардлагатай эм, тариа, хэрэгслээр бүрэн хангах;
11. Нийтийг хамарсан осол гэмтэл, халдварт өвчний дэгдэлт, хоолны болон бусад төрлийн хордлого, гал, усны аюул гарсан үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг хангах;
12. Эмнэлгийн яаралтай тусламж, сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасаг нэгжийн ор, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллах;
13. Түргэн тусламжийн автомашин, нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн болон багаж тоног төхөөрөмжийн бэлэн байлгах;
14. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг тусгай хуваарийн дагуу ажиллуулах;
15. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтны анхаарал сулрах, хариуцлага алдах, ажлын байрыг орхиж явах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх зэрэг асуудал гарахаас сэргийлэх зорилгоор байнгын хяналт тавьж ажиллах;
16. Эрүүл мэндийн байгууллагууд гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгож, байгууллагын барилга, байгууламж, бүтцийн болон бүтцийн бус /цахилгаан, усан хангамж, санхтехник/ - хэсгийг үерт автах эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч ажиллах;
17. Баяр наадам, АСЕМ-ийн үеэр эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд Эрүүл мэнд, спортын яамны хариуцлагатай жижүүрийн 323002 утсанд мэдээллийг шуурхай ирүүлэхийг анхааруулж байна.